

## **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

### Иргэдийн төлөөлөгчдийн рулын үйл ажиллагааны талаар

03-р сарын 11-ний өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит хурал боллоо. Хурлаар Улаангом сумын Хот тохижилт үйлчилгээний газрыг “Улаангом тохижилт үйлчилгээ” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар болгох, Увс нуурын дэргэдэх жуулчны баазын менежментийн гэрээг дуусгавар болгох, хөрөнгийн асуудлууд, 2 сум, 1 сургууль, 1 цэцэрлэгийн ой тэмдэглэх тухай, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог батлах тухай, Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай ажлын бүрэлдэхүүн түүний ажиллах чиг үүргийг батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Увс аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбатын санаачлагаар “Мөнхжим Өргөө” ХХК-ны нэрэмжит хойд бүсийн сумдын Математик, Англи хэл, Сэтгэх чадварын олимпиад 2019 оны 03-р сарын 15-ний өдөр Сагил суманд зохион байгуулагдлаа. Хоёр дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа уг олимпиад Математик 6,7,8,9-р анги, Англи хэл 6,7,8,9-р анги, Сэтгэх чадвар 1, 2-3, 4-5-р анги гэсэн насны ангилалаар явагддаг бөгөөд Давст, Сагил, Түргэн, Бөхмөрөн, Тариалан сумдын ерөнхий боловсролын сургуулийн нийт 120 гаруй сурагчид 11 багц 33 медалийн төлөө оюун ухаан, эрдэм мэдлэгээ сорьлоо.

Аймгийн ГХУСАЗСЗ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зам тээврийн осол хэргийг бууруулах, шалтгаан нөхцөл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэх зорилгоор “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХАМТДАА” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд “Увс-АЗЗА” ТӨК, Хот тохижилт үйлчилгээний газар, аймгийн ЭМГ, Увс аймаг дахь авто тээврийн төв, Түмэнд нээлттэй хязгаарынхан ХХК-д тус тус оролцлоо.

Аймгийн усны сав бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай сургалтыг Увс нуур- Тэс голын сав газрын захиргаатай хамтран Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд зохион байгууллаа.

### Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын ажлаараа улсад Улсад 2-р байр эзэллээ.

Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Л.Сүх-Очираар ахлуулсан ажлын хэсэг Увс аймагт ажиллалаа.Цаашид иргэдийн өргөдөл гомдол мэдээллийг хянан бүртгэж төрийн байгууллагын албан тушаалтнуудаас гаргасан тушаал, шийдвэр, төлбөр хураамж тогтоосон баримт бичиг, төсөв санхүү, худалдан авах үйл ажиллагаа, концессийн гэрээтэй танилцаж, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж шалгаж ажиллах юм.

Аймгийн ЗДТГ, Улаангом сумын ЗДТГ, аймгийн БТСГазар хамтран "Эрүүл Агаар-идэвхтэй амралт" бүх нийтийн өдөрлөгийг Чандмань Улаан-Ууланд зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга агентлагийн дарга нар, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нартай гүйцэтгэлийн гэрээ байгууллаа. 2019 оныг “Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах жил” болгон зарласантай холбогдуулан шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх, орон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж Монгол улсын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах чиглэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлт бүрээр тооцсоны үндсэн дээр агентлагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх юм.

Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга хурандаа М.Энх-Амараар ахлуулсан шуурхай бүлэг ЗУвс аймагт ажиллалаа. Шуурхай бүлэг, аймгийн онцгой комиссын гишүүдийн хамтаар хаваржилт хүндрээд байгаа Өлгий, Өмнөговь, Тариалан сумын удирдлагуудтай уулзаж хаваржилтын талаар мэдээлэл сонсож, малчин өрхүүдээр орж, нүүдлийн штабын байдалтай танилцан, улсын нөөцийн өвс тэжээлийг хөнгөлөлттэй үнээр сумдад хуваарилах ажлыг шуурхай зохион байгууллаа. ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд, хэрэгжээгүй болон эрчимжүүлэх шаардлагатай заалтууд, 2019 онд хийгдэхээр төлөвлөгдсөн томоохон ажлуудын талаар төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нарт мэдээлэл хийж, байгууллагын түвшинд цаашид анхаарч ажиллах асуудлуудын талаар харилцан санал солилцлоо. Мөн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нэгдсэн эмнэлэг, Улаан загалмайн хороотой хамтран “ Олон Улсын эмэгтэйчүүдийн баяр”-ыг угтаж өрх толгойлсон эмэгтэйчүүдийг хамруулсан “Ээж байх нь хамгийн сайхан” сэдэвт уулзалт ярилцлагыг зохион байгууллаа.

ХХААХҮ-ийн яамны сайдын зөвлөлийн хурлаар Увс аймгийн Өлгий сумын Өлгийн улаан омгийн ямаа албан ёсоор Үүлдэр болон батлагдлаа. Ингэсээр орон нутгийн брэнд бүтээгдэхүүн нэгээр нэмэгдэж, нутгийн малчдын орлого, санхүү сайжрах олон давуу талтай блдж байна. Өлгийн Улаан омгийн ямааг үүлдрээр баталгаажуулах ажил 2017 оны 5 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн ба уг ажлын хүрээнд Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан аймаг, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хамтран ямаанд чиглэсэн үржил селекцийн ажлыг зохион байгуулсан.

Аймгийн ЗДТГ-ын НБХ-ээс Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ахмад багш Дэлэг болон ЭМГ- тай хамтран ажиллаж Улсын тэргүүний Цогцолбор 1, 2- р сургуулийн ахлах ангийнханд Угийн бичиг хөтлөх, цус ойртолт түүний хор уршгийн талаар сургалт зохион байгууллаа.

Мөн хөтөлбөрийн хүрээнд эрэгтэйчүүдийн дунд сургалт, хэлэлцүүлэг ярилцлагыг зохион байгууллаа. Энэхүү сургалт хэлэлцүүлгийн үр дүнд анх удаагаа аймгийн хэмжээнд эрэгтэйчүүдийн нийгмийн оролцоо манлайллыг дээшлүүлэх зорилго бүхий "Увс хийморилор эрчүүд" клуб байгуулагдан тэргүүнээр нь ЭМГ- ын мэргэжилтэн Содном сонгогдон ажиллахаар боллоо.

Цаашид цахим сүлжээ групп үүсгэн эрчүүдийнхээ талаар санаа бодлыг нь сонсож НБХ- тэй хамтран ажиллах, тэдний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэгт дүн шинжилгээ хийж тэднийг уриалан ажил зохион байгуулах , нийгэмд эрчүүдийнхээ оролцоо манлайллыг дээшлүүлэх, нийгмийн хариуцлагаа ухамсарлан

гэр бүл, бусдын төлөө ойлголт хандлагаа дээшлүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах боллоо. Мөн энэхүү үйл ажиллагааг дэмжин Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч Гансүх эрчүүдийн эрүүл мэндийн талаар сургалт мэдээллийг хийлээ.

ЗДТГ-ын ХЭЗХ-ээс “Эрх зүйн боловсрол” дэд хөтөлбөрийн хүрээнд “Насан туршийн боловсролын төв” -тэй хамтран “Мэдээлэл хандлагын богц” аянг зохион байгууллаа. Аяныг зохион байгуулснаар иргэд олон талт хэлбэрээр эрх зүйн болоод төрийн байгууллагын талаарх мэдээ мэдээллийг энгийн ойлгомжтой хэлбэрээр хүртээмжтэй хүлээн авах, санал хүсэлтээ хүргэх боломж бүрдэж байгаа юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын аймгийн комиссын төлөвлөгөөний дагуу тооллогын бэлтгэл хангах ажлын хүрээнд бүсчилсэн сургалтуудыг зохион байгууллаа. Сургалтад төвийн бүс буюу Улаангом сумын статистикч, ХАОСТ-ын түр товчооны гишүүд оролцлоо.

ЗДТГ-ын ТЗУХ агентлагуудад ажиллалаа. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, “Төрийн албан хаагчийн сахилга дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилт, ажлын цаг ашиглалт, хүрээнд Төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын байрны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, шинэчлэгдэн батлагдсан Төрийн албаны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын явц хяналт-шалгалт хийж, зөвлөмж чиглэл өглөө.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

#### Увс аймаг 2019 оны 03 дугаар сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээ

Төсвийн зарлага а) Эхний 3 сарын төсвийн зарлага 16 366,3 сая төгрөг буюу 72.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 4 582,1 сая төгрөг буюу 27,9 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 11784,4 сая төгрөг буюу 72,1 хувийг тус тус эзэлж байна. б) Төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл нийт зарлагын 63,7 хувийг цалин НДШ, 2,5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 3,4 хувийг нормативт зардал буюу эм, хоол, нормын хувцасны зардал, 4,0 хувийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал тус тус эзэлж байна. в) Сумдад 3958,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 10282,1 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 245,0 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус олгосон байна.

1-р улиралд нийт 1,788,500,000 төгрөг төвлөрүүлхээс 1,986,830,700 төвлөрүүлж 111,1% биелэлттэй байна.

Татварын төрөл	Сарын			Өссөн		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>Сум, дүүргийн төсөв</b>	<b>116,500.00</b>	<b>123,543.98</b>	<b>106.0%</b>	<b>390,500.00</b>	<b>487,645.97</b>	<b>124.9%</b>
Агнуурын нөөцийн төлбөр	3,000.00	-	0.0%	10,000.00	11,606.00	116.1%
Газар эзэмших, ашиглах эрх		618.09			2,010.99	

борлуулсны орлого						
Галт зэвсгийн албан татвар	500.00	690.00	138.0%	1,500.00	1,650.00	110.0%
Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого /Суутган-3/	65,000.00	66,940.63	103.0%	250,000.00	330,973.92	132.4%
Иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	2,000.00	5,000.00	250.0%	14,000.00	21,100.58	150.7%
Нэр заагдаж ангилагдаагүй бусад орлого	6,000.00	7,814.69	130.2%	14,000.00	31,018.08	221.6%
Ойн нөөцийн төлбөр	-	853.35	#DIV/0!	-	2,596.93	#DIV/0!
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5,000.00	191.00	3.8%	6,000.00	1,201.16	20.0%
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.00	4,367.21	145.6%	12,000.00	11,249.31	93.7%
Ус, рашаан ашигласны төлбөр	3,000.00	391.76	13.1%	4,000.00	1,671.25	41.8%
Хог хаягдлын хураамж	12,000.00	214.00	1.8%	34,000.00	20,665.00	60.8%
Хувь хүний орлогын албан татвар	9,000.00	16,832.46	187.0%	24,000.00	24,915.54	103.8%
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	8,000.00	19,630.80	245.4%	21,000.00	26,987.23	128.5%
<b>Улсын төсөв</b>	<b>319,200.00</b>	<b>482,311.17</b>	<b>151.1%</b>	<b>751,100.00</b>	<b>1,153,308.59</b>	<b>153.5%</b>
Автын агаарын бохирдлын төлбөр	1,400.00	823.41	58.8%	2,700.00	1,904.11	70.5%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	39,000.00	42,511.43	109.0%	99,600.00	95,641.03	96.0%
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	6,000.00	24,690.84	411.5%	16,000.00	53,495.42	334.3%
Дотоодын архины онцгой албан татвар	20,800.00	20,800.00	100.0%	53,800.00	75,800.00	140.9%
Дотоодын бараа, үйлчилгээний НСАН	252,000.00	393,485.49	156.1%	579,000.00	912,989.44	157.7%
Нүүрсний агаарын бохирдлын төлбөр		-	#DIV/0!		13,478.60	#DIV/0!
<b>Аймаг, нийслэлийн төсөв</b>	<b>573,000.00</b>	<b>577,706.86</b>	<b>100.8%</b>	<b>1,398,000.00</b>	<b>1,499,184.72</b>	<b>107.2%</b>
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	20,000.00	19,832.59	99.2%	30,000.00	34,803.16	116.0%
Бусад орлого	30,000.00	15,263.56	50.9%	70,000.00	42,368.60	60.5%
Газрын төлбөр	15,000.00	15,697.50	104.7%	30,000.00	25,191.95	84.0%

Үл хөдлөх хөрөнгийн татвар	70,000.00	43,868.54	62.7%	83,000.00	102,568.00	123.6%
Татварын торгуулийн орлого	4,000.00	1,983.00	49.6%	6,000.00	4,342.00	72.4%
Улсын тэмдэгтийн хураамж	14,000.00	9,230.80	65.9%	39,000.00	24,867.67	63.8%
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого \Суутган-1\	420,000.00	471,830.88	112.3%	1,140,000.00	1,265,043.35	111.0%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,008,700.00</b>	<b>1,183,562.01</b>	<b>117.3%</b>	<b>2,539,600.00</b>	<b>3,140,139.29</b>	<b>123.6%</b>

### Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

#### Хууль хяналтын үйл ажиллагаа:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны А/117 захирамжийн дагуу 2019 оны 03 дугаар сарын 12-ний өдөр Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж 2019 оны ажлын төлөвлөгөөгөө баталлаа.

2. Увс аймгийн Улаангом сумын ГХУСАЗСЗ, ИТХ, ЗДТГ-аас Улаангом сумын 12 баг хариуцсан цагдаагийн газрын хэсгийн байцаагч, багийн цагдаа нарт Улаангом сумын нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээ явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж хүлээлгэн өглөө.

3. цагдаагийн газраас Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, ЦЕГ-н даргын 2008 оны 125 тоот тушаалыг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагаас иргэдэд шуурхай хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэх, шинээр батлагдсан замын хөдөлгөөний дүрэм болон улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “НЭГ ХОРОМ ХҮЛЭЭ” аяныг сурталчлах зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд цагдаагийн газрын тасгуудын 2019 оны 01 дүгээр улирлын тайланг иргэдэд танилцуулсан. Цагдаагийн газар ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, алба хаагчдын тусгай хэрэгсэл, тусгай бүлгийн үзүүлэх тоглолт, урлагын тоглолтыг тус тус иргэд олон нийтэд сурталчилан, гэмт хэрэг зөрлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 10 төрлийн 180 ширхэг санамж, сэрэмжлүүлэгийг тараасан. Мөн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээг тодорхойлох зорилгоор 35 иргэнээс санал, асуулга авч ажиллалаа.

#### **Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:**

2019 оны 3 дугаар сарын байдлаар 152 гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл ирүүлснээс 65 гэмт хэрэг бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 27 нэгжээр буюу 29.3 хувиар буурсан байна.

Үүнээс хөнгөн гэмт хэрэг 54 гарч өнгөрсөн оны мөн үеэс 21 нэгжээр буюу 28 хувиар буурсан байна. Хүнд гэмт хэрэг 11 гарч өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгжээр буюу 35,3 хувиар буурсан байна.

Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 180 ирүүлснээс 68 зөрчилд зөрчлийн хэрэг нээж өнгөрсөн оны мөн үеэс 31 нэгжээр буюу 37 хувиар өссөн байна.

1 дүгээр улирлын байдлаар нийт 2953 зөрчил шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 703 нэгжээр буюу 31,2 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

### **Архивын ажлын мэдээлэл:**

1.Архивын тасгаас Архивын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан хяналтын улсын ахлах байцаагч Т.Сайнжаргалыг урьж 2019 онд явагдах Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангахад анхаарах асуудал, архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын чиглэлээр холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд 19 сумын ЗДТГ-ын дарга, хууль, эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, аймгийн Засаг даргын дэргэдэх 22 агентлагийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан нийт 80 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдлаа.

2.Увс аймгийн Төрийн архивт хөмрөг үүсгэсэн болон үйл ажиллагаа явуулж байгаа 162 байгууллагын 170 архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны мэргэжил, боловсролын судалгааг 2 дугаар сард гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүлэв.

3.Архивын баримтын Улсын нэгдсэн тоо бүртгэлийн нэгдсэн системд аймгийн төрийн архивт хөмрөг үүсгэгч болон татан буугдсан 237 байгууллагын баримтын мэдээг эхний улиралд багтаан оруулж баталгаажууллаа.

4. 1 дүгээр улирлын байдлаар аймгийн Архивын тасагт лавлагаа мэдээлэл авахаар ирсэн 308 иргэн бүртгүүлж, 257 иргэний лавлагаа мэдээллийг түргэн шуурхай гаргаж үйлчиллээ. Зарим байгууллагын баримт материал шилжиж ирээгүй, дутуу шилжин ирсэн баримтнаас шүүн үзэж гараагүй зэрэг шалтгаанаас 51 иргэний лавлагаа мэдээлэл гараагүй болно.

5. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Төрийн архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн архивын тасаг нь эхний улиралд 4 хөмрөг үүсгэгч байгууллагын 4 дансны 1953-2005 оны 140 хадгаламжийн нэгж баримтыг тодорхойлон бичиж, 12 хөмрөг үүсгэгч байгууллагын 12 дансны 335 хадгаламжийн нэгжийн 23024 хуудас баримтыг скайнердаж, 10 хөмрөг үүсгэгч байгууллагын 10 дансны 391 хадгаламжийн нэгжийн 12817 хуудас баримтанд холболт хийж, 7 хөмрөг үүсгэгч байгууллагын 7 дансны 260 хадгаламжийн нэгжийн 19877 хуудас баримтыг Photoshop программаа засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

6. Монгол улсын хэмжээнд 4 жил тутамд явагддаг “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор мэргэжил, арга зүйн туслалцаа авах хүсэлтийг Өндөрхангай сумаас ирүүлсний дагуу тус суманд Архивын тасгаас 3 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд ажиллалаа. Ажиллах хугацаандаа сумын ЗДТГ болон төсөвт байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт хийж, зөвлөн туслах ажлыг явууллаа.

7. Аймгийн Биеийн тамир, спортын газар, Стандарт хэмжил зүйн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Тэс, Ховд, Баруунтуруун, Өндөрхангай, Завхан, Бөхмөрөн сумдын ЗДТГ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа архив, албан хэрэг хөтлөлтийн AMS-G цогц программыг шинэчлэн, ашиглалтын талаар заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.

8. Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, “Төрийн албан хаагчийн сахилга дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын байрны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажилд хяналт-шалгалт хийх, чиглэл зөвлөмж өгөх ажлын хэсэгт архивын тасгийн архивч хамрагдан 3 дугаар сарын сүүлийн 7 хоногт аймгийн төвийн зарим албан байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. /Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар гэх мэт/

9. Архивын нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд эхний улиралд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн 21 хадгаламжийн нэгж баримтыг архивын сан хөмрөгт хүлээн авлаа.

10. Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Архивын тасгийн ажилтнууд зарим хөмрөг үүсгэгч байгууллагын гэмтсэн баримтыг үдэж хавтаслах, цэгцлэх ажлыг сар бүрийн 2 дахь 7 хоногийн пүрэв гарагт зохион явуулж байна.

### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

#### **Боловсрол:**

Ерөнхий боловсролын сургуулийн 32 дотуур байранд 6 алхамт хэвшүүлэх ажил. Хичээлийн бусад цагийн нэмэлт хөтөлбөрийн дагуу хүүхдийн нас сэтгэцийн онцлогийг харгалзан, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор дотуур байруудад хэвшүүлэх 6 АЛХАМТ ажлуудыг хэрэгжүүлж байна.

“Монгол зан үйл, амьдрах ухааны өргөө”-г 24 сургуулийн 33 дотуур байранд байгуулж ажиллаж байна.

“БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ ” төслийн 4 шатны орон нутгийн багш нарыг чадавхжуулах сургалтыг 28 сургуулийн 446 багшид 2019 оны 01.01-02.15 хүртэл зохион байгуулж ,багш удирдлагууд төсөл бичих аргад суралцсан.БЧШ-ийн төслийн 4 шатанд оролцох төсөлд арга зүйн зөвлөгөө өгч дахин ажилласнаар 27 сургуулийн 38 төсөл бичигдсэн.

БАГШ СУРАГЧИЙН ГЭРТ АЯН-3: Хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшлийн асуудлаар эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах ажлыг тогтмолжуулж, хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Багш сурагчийн гэрт-3” аяныг 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд ЕБС-ын 736 багш 5892 сурагчийн гэрээр, СӨБ-ын 272 багш 3572 хүүхдийн гэрээр очиж хүүхэд, эцэг эхтэй уулзаж сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг сурталчилж, санал бодлыг нь тусгана ажилласан.

Увс аймгийн ИТХ болон ОХУ-ын Тува улсын Дээд хурлын хамтын ажиллагааны хүрээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын 6 сургуулийн 8-9-р ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Я люблю русский язык" танин мэдэхүйн уралдаан 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.



Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллгааны хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд "ХАМТДАА ХАНДЛАГАА ӨӨРЧИЛБЕ" гэсэн уриатайгаар баруун бүсийн "ЭКО"-логийн анхдугаар олимпиадыг 2019 оны 04 сарын 01-03-ний өдрүүдэд ДБХС-ийн Ирвэстэй нутгийн ирээдүй төсөлтэй хамтран зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаад байна.

#### Эрүүл мэнд:

Дэлхийн эмч нарын өдрийг угтан эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгууллаа.

ОНХС-ийн санхүүжилтээр Өлгий, Зүүнговь, Тариалан, Ховд, Зүүнхангай сумын эрүүл мэндийн төвүүдэд 100.0 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг гардууллаа.

#### Нийгмийн хамгаалал:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Жендэрийн салбар хорооноос ХХҮГ-тай хамтран Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан зорилтот бүлгийн Өрх толгойлсон 35 ээж оролцсон “Ээж байх нь хамгийн сайхан” арга хэмжээ зохион байгуулж, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, жендэрийн асуудлаар мэдээлэл өгч, Засаг даргын гарын бэлэг 30000 ₮, сарнай цэцэг бэлэглэлээ.

Байгууллагуудын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нарт жендэрийн дэд хөтөлбөр танилцуулах уулзалт ярилцлага зохион байгуулж цаашид хийх ажлын чиглэлээ тохирлоо.

Аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 1000 гаруй хүүхдэд Ураг удам уламжлалын холбоо, ЭМГ-тай хамтарч угийн бичиг хөтлөлт, цус ойртолт сургалт, АХА тэмцээн, нийгмийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн мэдээлэл өгсөн.

Эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам уулзалт ярилцлагыг зохион байгуулж, Жендэрийн хөтөлбөр, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл өгч, аймагт анх удаа эрэгтэйчүүдийн ТББ-ын үндэс суурь болох “Хийморьлог эрчүүд” клуб үүсгэн байгуулагдаж, хийх ажлын төлөвлөгөө батлан ажиллаж эхэллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээг байгууллагууд сар бүр зохион байгуулахаар хуваарь хийж хүргүүллээ. Ерөнхийлөгчийн тамгын газарт Алдарт эх 1 одонгоор 36, Алдарт эх 2 одонгоор 335 эхийг шагнуулахаар уламжлахаар боллоо.

Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл хуралдаж 2019 онд аймагт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжих хөтөлбөрүүдийн хуваарь баталж, төслүүд зарлаж эхлээд байна.

“Сумаас мэдээлж байна” ТВ булан ажиллуулж нийгмийн салбарын хүрээнд орон нутагт хэрэгжүүлж байгаа шинэлэг ажлуудыг олон нийтэд сурталчилж эхэллээ.



2019 онд амьжиргааг нь дэмжин ажиллах зорилтот 406 өрхийг сонгон баталгаажуулж тэдгээр өрхүүдийн хэрэгцээг тодорхойлох нөхцөл байдлын үнэлгээ хийж өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байна.

Сайн дурын даатгалын хамралт болон нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах "Хамгийн олон сайн дурын даатгуулагчидтай сум, "Хамгийн олон даатгуулагч сайн дурын даатгалд хамруулсан байцаагч" уралдаан зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Эхний 3 сард 122 ажлын байрны захиалга авч, 96 иргэнийг ажилд зуучилсан байна.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### Газар тариалан:

1. Аймгийн ЗДТГ-аас Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн /GIZ/ "Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага" хөтөлбөртэй хамтран 2019 оны 3-р сарын 9-11-ний өдрүүдэд "Жимс жимсгэнэ тарих, залгах үржүүлэх арга" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилчид, тариаланчдын төлөөлөл 12 хүн хамрагдаж сургагч багшийн сертификат гардан авлаа.

#### Мал аж ахуй:

1. 2019.03.28-ны байдлаар оны эхний төллөх ёстой хээлтэгчийн 24,5% буюу 346876 толгой хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 95,1% буюу 315213 толгой төл бойжиж байна. Аймгийн хэмжээнд нийт 60626 толгой мал хорогдсоноос тэмээ 33, адуу 1197, үхэр 2312, хонь 28085, ямаа 28999 толгой хорогдоод байгаа нь нийт малын 1,9%-ийг эзэлж байна.
2. Аймгийн онцгой байдлын комиссын хуралдаан зохион байгуулж 4 ажлын хэсэг томилогдон хаваржилт хүндэрч буй 12 суманд ажиллаа. Ажлын хэсэг сумын өвс тэжээлийн нөөц, бэлчээрийн даац, малчдын ахуй байдалтай танилцаж холбогдох арга хэмжээг авлаа. Улсын нөөцөөс 400 тн өвс, 400 тн тэжээл, аймгийн нөөцөөс 80 тн тэжээлийн 50%-ийн хөнгөлөлттэй нөхцөлөөр малчдад олгох шийдвэр гаргалаа.

#### Жижиг дунд үйлдвэрлэл:

1. ХХАА-н салбарын мэргэжилтэнгүүдийн аймгийн зөвөлгөөн зохион байгууллаа. Зөвөлгөөний үеээр бүх сумын Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэнгүүдэд сум хөгжүүлэх сангийн шинчлэгдсэн програмын сургалт хийлээ.
2. Давсны хэрэглэглээг бууруулах аяны нээлт хийлээ.
3. Хүнс хөдөө аж ахуйн яамнаас "Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийг тогтоох норматив"-ийг шинэчлэн боловсруулах сэдвийн хүрээнд 3 сарын 03 –ны өдөр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт холбогдох агентлаг, байгууллагаас 18 хүн оролцож 22% нь ХХААХҮ-ийн сайдын "Норматив тогтоох тухай тушаал"-ын саналыг дэмжиж 78% нь дэмжсэнгүй.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

### Байгаль орчин:

Тэмээ-Мөс-Засагчлалын баярыг аймгийн ЗДТГ, БОАЖГ, Завхан сумын ЗДТГ, Ойрад ХЖТ, "Сайхан Халиун" ХХК хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 180 гаруй тэмээтэй парад, хурдан тэмээний уралдаан, ганган тэмээтэй сайхан хос, зан үйлийн / бурантаг томох, буйл зорох/ болон сайхан буур, ингэ шалгаруулах зэрэг уралдаан тэмцээнүүд зохион байгуулагдлаа. Увс аймгийн Наранбулаг, Өлгий сум, Ховд аймгийн Дөргөн, Говь-алтай, Завхан аймгаас уяачид тэмээгээ оролцууллаа.

Мөс-Загасчлал-2019 өдөрлөгийг Хяргас нуурт зохион байгуулсан бөгөөд Загасчлалын тэмцээнд 21 баг өрсөлдсөн бөгөөд уг арга хэмжээнд ОХУ-ын Красноярский хотоос 15, Тува улсын 5, АНУ-ын сайн дурын ажилтан зэрэг 22 жуулчид ирж тэмцээн уралдаанд оролцлоо.

Наадмыг үзэж сонирхохоор ирсэн иргэд, ААН-ийн дунд мөсний сумо, мөсний олс таталт, мөсний шагай зэрэг тэмцээнийг тус бүр зохион байгуулсан ба арга хэмжээг Улаанбаатар, Увс аймгийн Төр захиргааны байгууллага, ААН, иргэд, гадаадын 20 гаруй аялагч жуулчид нийт 2000 гаруй хүмүүс үзэж, оролцсон.

ИТМ-2019 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2019 оны 03 сарын 29-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Оролцогчдын цар хүрээ, зохион байгуулалтаараа хамгийн томоохонд тооцогддог энэ үзэсгэлэнгийн хамтран зохион байгуулагч, түншлэгч аймгаар Увс аймаг оролцсон бөгөөд аймгийн удирдлагууд, ЗДТГ, БОАЖГ болон бусад салбарын байгууллагууд, Ойрад хөгжимт драмын театр, аймгийн Музей, гар урлал, бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидийн төлөөлөл зэрэг 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцлоо.

Дэлхийн усны өдрийг угтаж “Цэнгэг ус тэгш хүртээмж” сэдвийн дор сарын аян зохион байгууллаа. Аяны хүрээнд 15 төрлийн ажил төлөвлөж, экоклубын сурагчдын дунд эссэ бичлэг, гар зургийн уралдаан, АХА тэмцээн, ус ашиглагчдын дунд сургалт, олон нийтийн телевизээр сурталчилгаа, шторкыг явуулсан ба ажлаа дүгнэн Ю.Цэдэнбалын талбайд “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” зохион байгууллаа. Нээлттэй хаалганы өдөрт 220 гаруй иргэнд гарын авлага брошур тарааж, сурталчлах ажлыг хийсэн.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд Усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийн зураглалыг танилцуулах өдөрлөгийг Хар тэрмэс жуулчны баазад зохион байгууллаа. Өдөрлөгт Увс аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, нарийн бичгийн дарга Х.Дашзэвэг болон хурлын тэргүүлэгч, төлөөлөгч, ажлын алба, сав газрын захиргааны төлөөлөл нийт 50 хүн оролцлоо.

3 сарын 15- 23-ны хооронд Улаанбаатар хотод Монгол улсад Ус цаг уурын алба үүсч хөгжсөний 95 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулагдсан. Арга хэмжээнд УЦУОШТөвөөс нийт 15 хүн оролцсон. Ой угтсан спортын гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, теннис, шатар гэсэн төрлүүдэд эрэгтэй эмэгтэй багууд амжилттай оролцлоо. /Шатар 4-р байр, теннис 5-р байр, сагсан бөмбөг – Эмэгтэй баг 3-р байр эзэлж Өргөмжлөл, хүрэл медалиар шагнууллаа/

3-р сарын 30-нд “Эх дэлхийн цаг” арга хэмжээг Улаангом сумын хэмжээнд ЕБС-ийн экоклубын сурагчид, албан байгууллага, иргэдийн дунд зохион байгуулав. Нийт 450 гаруй иргэд, сурагчид оролцож, эх дэлхийн цаг арга хэмжээнд нэгдэж, 1 цагийн турш цахилгаан хэмнэх арга хэмжээг зохино байгууллаа.

6. Хууль бус ан агнууртай тэмцэх “Шуурхай баг” байгуулах асуудлыг Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоол гаргаж байгуулав. Шуурхай багийн үйл ажиллагаа явуулах байрыг МХГ-т 1 өрөөнд засвар хийж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэхэд бэлэн болоод байна.

Хархираа уул, Цагаан шувуутын ДЦГ-ын орчинд байгаа газар нутгуудийг ОНТХГ-т авах хэлэлцүүлгийг Улаангом, Түргэн, Сагил суманд зохион байгуулж, хэлэлцүүлэгт холбогдох 60 гаруй хүмүүс оролцсон.

#### Дэд бүтэц:

2019 оны 3 дүгээр сарын 13-15-нд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас ГХБХБГ-ын үйл ажиллагаанд хяналт мониторинг хийгдэж, зөвлөн туслах ажил явагдав. Мөн аймгийн удирдлагуудад Монгол улсын хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төсөл боловсруулах үйл ажиллагааг танилцуулж, санал, чиглэл өглөө.

2019 оны 3 дүгээр сарын 27-нд Увс аймгийн хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын төвийн бүсийн сургалт зохин байглагдлаа.

“Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний VII зөвлөгөөн 2019” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотод 2019 оны 3 дүгээр сарын 22-23-нд зохион байгуулагдсан “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2019”, “Хот байгуулалт, газрын харилцааны салбар зөвлөгөөн-2019”, барилгын паспортжуулалтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, мэдлэг чадвар олгох сургалтад Увс аймгийг төлөөлж ГХБХБГ-ын дарга Ц.Энхбаатар, ГХБХБГ-ын мэргэжилтэн Б.Батболд, Чандмань Увс ХХК-ий дарга М.Мөнхөө, Тоосгон Уул ХХК-ий захирал Д.Алдар, Зоос Импекс ХХК-ий захирал Т.Батзориг, Арвижих Увс ХХК-ий инженер Ч.Батболд, Цагаан хөшөө трейд ХХК-ий инженер Б.Тэлмэн нар оролцлоо.

Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний иж бүрэн зураг төслийг Сангийн яамны Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн нэгжийн захиалгаар Урбан девелопмент групп ХХК боловсруулсан бөгөөд Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн нэгж орон нутагт зураг төслийг хүлээлгэн өглөө. Ингэснээр барилга угсралтын ажил эхлэх нөхцөл бүрдлээ.

.....оОо.....